

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/26/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 261628 Цахим хаяг: Battsetsepp@audit.gov.mn Аудитор: С.Алтанхуяг Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 261628 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	17
3.4.2 Авлага	19
3.4.3 Урьдчилгаа	20
3.4.4 Бараа материал	20
3.4.5 Нөөцийн бараа	21
3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө	22
3.4.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт	23
3.4.8 Үндсэн хөрөнгө	23
3.4.9 Өр төлбөр	24
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо	26
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	27
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	27
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	27
3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт.....	29
3.5.4 Нэмэлт төсөв	32
3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	32
3.5.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	33
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	35
4.1 Ерөнхий зүйл	35
4.2 Материаллаг байдал.....	35
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	35
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	35
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	36
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	36
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	37
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	38
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	39
5.1 Харьяа байгууллагууд.....	39
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч.....	39
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	45

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНБУ	Бүгд Найрамдах Беларусь Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОТ	Бага оврын трактор
ЖДҮХБОХ	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЖДҮГ	Жижиг дунд үйлдвэрийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулах
МЭЭСБУЛ	Малын эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори
НА	Нийцлийн аудит
МААЭЗЭНТ	Мал аж ахуй эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУБ	Олон улсын байгууллага
ӨТБГ	Өр төлбөр барагдуулах гэрээ
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
САГ	Санхүүгийн аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШОЖ	Тендер шалгаруулалтын онцгой журам
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УИХ	Улсын Их хурал
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТП	Үйлдвэр, технологийн парк
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮХОБ	Үндэсний хөрөнгө оруулалтын банк
ХААК	Хөдөө аж ахуйн корпораци
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШГБ	Шууд гэрээ байгуулах



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ц.ИДЭРБАТ ТАНАА

2026.04.27 № 1152
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- ХХААХҮЯ-ны харьяа байгууллагууд Дархан-Уул аймагт нүүсэнтэй холбогдуулан албан хаагчдад олгосон орон сууцны урьдчилгаа төлбөрөөс гэрээний үүргийн биелэлт хангаагүй /өөр байгууллагад шилжин томилогдсон, зээлийн шаардлага хангаагүй/ нийт 8 албан хаагчийн 459.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Тайлант хугацаанд ЖДҮХСан нь 11 аймагтай гэрээ байгуулан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжилтэд 6,635.8 сая төгрөгийг төвлөрүүлснээр тус байгууллагын төсвийн гүйцэтгэл 2,365.3 сая төгрөгөөр хэтэрсэн нь төсөв батлах цаглаварт

хугацаанаас хамаарч уг төсвийг төлөвлөх, батлах боломжгүй нөхцөл байдал үүссэн;

- ХХААХҮС-ын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 тушаалаар батлагдсан Төсвийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг удаа дараа хийж, батлагдсан хөтөлбөр арга хэмжээний мөнгөн дүнд материаллаг хэмжээний өөрчлөлтийг оруулж, төсвийн тогтвортой байдлыг мөрдөж ажиллаагүй;
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 212,403.0 сая төгрөгийн 194 зөрчил илэрсэнд 72.1 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 108,973.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 84 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлагыг хүргүүлж, 16,336.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 77 зөвлөмжийг өгсөн;

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүсчилсэн хөгжлийн бодлогын төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс" болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагууд нь Дархан-Уул аймагт 2024 оноос үе шаттай шилжин байршиж, үйл ажиллагаа явуулж байгаа ба тус яамнаас хэрэгжүүлж байгаа "Хүнсний хувьсгал", "Атрын IV", "Цагаан алт" зэрэг хөтөлбөрүүдэд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөөгөөр аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт "Аж ахуй нэгжийн орлогын албан татвар"-ын гүйцэтгэл 69.9 хувиар буюу 6,793.9 сая төгрөгөөр давж биелсэн, мөн орон нутгийн төсөвт 9,802.1 сая төгрөгийн төлбөр, хураамж, шимтгэлийг төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

"Монгол Улсын Засгийн Газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх" бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 126 төрийн албан хаагчдад 7.4 тэрбум төгрөгийн орон сууцны урьдчилгааг олгосон, Баянзүрх дүүрэгт байршилтай 8287м.кв газар эзэмших эрх, агуулах, аж ахуйн зориулалттай барилга байгууламжийг нээлттэй дуудлага худалдаагаар 1,109.2 сая төгрөгөөр худалдан борлуулж, тус аймагт албан хэрэгцээний дөрвөн үл хөдлөх хөрөнгийг 801.9 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулсан зэрэг байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтаар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан байна.

“Монгол Улсын Засгийн Газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/96 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,185,214,241.5	1,198,450,459.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	329,154,084.2	308,452,672.8
33	АВЛАГА	588,701,360.0	610,439,362.6
34	УРЬДЧИЛГАА	7,170,514.0	5,744,666.9
35	БАРАА МАТЕРИАЛ	85,442,041.5	80,491,731.5
36	НӨӨЦИЙН БАРАА	101,355,462.8	76,175,279.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	73,390,779.0	117,146,745.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	254,888,656.5	273,879,404.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	35,000,000.0	30,000,000.0
37300	Урт хугацаат зээл	35,000,000.0	30,000,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	219,888,656.5	243,879,404.3
39200	Биет хөрөнгө	171,101,041.2	181,194,817.4
39300	Биет бус хөрөнгө	48,787,615.3	49,171,111.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	13,513,475.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,440,102,898.0	1,472,329,863.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	788,793,865.4	908,462,476.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	131,742,291.4	273,045,619.5
41200	Богино хугацаат зээлийн өглөг	440,334.6	384,895.5
41300	Өглөг	123,075,830.4	271,386,838.8
41400	Урьдчилж орсон орлого	8,226,126.4	1,273,885.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	657,051,574.0	635,416,857.1
42200	Урт хугацаат зээл	657,051,574.0	635,416,857.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	651,309,032.6	563,867,386.9
51	Засгийн газрын хувь оролцоо	651,309,032.6	563,867,386.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	137,931,064.7	144,081,062.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	93,094,010.2	94,578,929.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10.0	10.0
51200	Хуримтлагдсан үр дүн	381,647,269.8	285,959,959.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,636,677.9	39,247,425.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,440,102,898.0	1,472,329,863.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	785,896,451.1	584,750,064.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,728,990.3	584,750,064.4
120	Нийтлэг татварын бус орлого	126,728,990.3	127,325,167.5
122	Тусламжийн орлого	-	457,424,896.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	659,167,460.8	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	596,033,515.0	647,954,335.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	596,033,515.0	647,954,335.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	257,107,267.5	259,748,125.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,922,462.4	64,194,514.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,030,891.4	8,876,056.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,241,695.3	3,090,336.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,589,073.7	16,772,915.6
2105	Нормативт зардал	28,867,832.4	30,951,150.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,256,931.6	1,324,917.7
2107	Томилолт, зочны зардал	3,049,317.1	2,018,346.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,356,666.0	107,521,810.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,792,397.6	24,998,078.0
211	ХҮҮ	6,972,290.9	6,819,279.1
212	ТАТААС	316,102,728.2	373,901,463.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,851,228.4	7,485,468.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	189,862,936.1	(63,204,271.0)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	34,583,427.4	12,293,720.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	101,485,135.4	36,089,425.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(66,901,708.0)	(23,795,704.9)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	122,961,228.1	(86,999,975.9)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,166,754,712.8	957,815,671.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	482,849,757.1	957,815,671.6
120	Нийтлэг татварын бус орлого	482,849,757.1	499,735,833.2
122	Тусламжийн орлого	-	458,079,838.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	683,904,955.7	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	882,495,184.4	821,507,455.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	882,495,184.4	821,507,455.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,218,830.9	547,358,746.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,248,108.7	72,682,961.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,133,723.6	10,012,357.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,983,712.5	4,151,129.2
2104	Хангамж, бараа материалын зардал	53,486,174.2	61,495,002.0
2105	Нормативт зардал	29,777,468.2	8,734,728.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,471,297.5	2,528,394.1
2107	Томилолт, зочны зардал	3,051,156.7	1,454,785.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	337,236,129.4	381,736,729.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,831,060.1	4,562,658.7
211	ХҮҮ	6,972,290.9	6,784,183.2
212	ТАТААС	311,102,728.2	244,365,605.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,201,334.4	22,998,920.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	284,259,528.4	136,308,215.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,499,607.3	233,494.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	117,152,202.0	54,541,566.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	117,152,202.0	54,541,566.2
2200	Дотоод эх үүсвэрээр	117,152,202.0	54,541,566.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(112,652,594.7)	(54,308,071.4)
14	Бусад эх үүсвэр	3,502,352.2	1,054,006.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	69,836,062.8	95,339,738.3
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	14,702,785.4	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	12,804,732.8	8,415,823.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(93,841,228.8)	(102,701,555.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	77,765,704.9	(20,701,411.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	251,388,379.3	329,154,084.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	329,154,084.2	308,452,672.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	532,240,386.9		532,240,386.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	423,416.2		423,416.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	532,663,803.1		532,663,803.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(180,561.7)		(180,561.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	605,170.5		605,170.5
7	Өмчид гарсан өөрчлөлт	(4,740,607.4)		(4,740,607.4)
9	Тайлант үеийн үр дүн	122,961,228.1		122,961,228.1
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	651,309,032.6		651,309,032.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,099,643.9)		(2,099,643.9)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	649,209,388.7		649,209,388.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	611,022.7		611,022.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(10,277.3)		(10,277.3)
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,474,918.9		1,474,918.9
18	Зарласан ногдол ашиг	(417,690.1)		(417,690.1)
19	Тайлант үеийн үр дүн	(86,999,975.8)		(86,999,975.8)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	563,867,386.9		563,867,386.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	725,114,670,000.00	490,843,945,571.01	234,270,724,428.99	67.7
Татварын бус орлого	725,114,670,000.00	490,843,945,571.01	234,270,724,428.99	67.7
Нийтлэг татварын бус орлого	48,857,642,200.00	53,416,310,623.57	(4,558,668,423.57)	109.3
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	48,636,110,500.00	46,010,333,758.94	2,625,776,741.06	94.6
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	221,531,700.00	7,405,976,864.63	(7,184,445,164.63)	3,343
Тусламжийн орлого	676,257,027,800.00	437,427,634,947.44	238,829,392,852.56	64.7
Төсвөөс санхүүжих	676,257,027,800.00	437,427,634,947.44	238,829,392,852.56	64.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	662,636,276,400.00	475,214,866,018.49	187,421,410,381.53	71.7
УРСГАЛ ЗАРДАЛ	618,830,470,000.00	396,136,964,775.41	222,693,505,224.59	64.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,845,866,100.00	146,559,212,459.63	45,286,653,640.37	76.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,455,709,400.00	58,201,847,092.67	1,253,862,307.33	97.9
Үндсэн цалин	34,387,085,800.00	32,587,921,829.30	1,799,163,970.70	94.8
Нэмэгдэл	16,546,762,100.00	16,056,486,405.85	490,275,694.15	97.0
Унаа хоолны хөнгөлөлт	4,922,291,600.00	6,058,349,138.16	(1,136,057,538.16)	123.1
Урамшуулал	3,599,569,900.00	3,499,089,719.36	100,480,180.64	97.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,639,871,800.00	7,378,699,446.39	261,172,353.61	96.6
Тэтгэврийн даатгал	5,212,163,300.00	5,050,108,428.86	162,054,871.14	96.9
Тэтгэмжийн даатгал	615,194,300.00	582,199,527.13	32,994,772.87	94.6
ҮОМШӨ-ний даатгал	318,696,600.00	327,287,815.38	(8,591,215.38)	102.7
Ажилгүйдлийн даатгал	299,308,900.00	287,425,081.23	11,883,818.77	96.0
Эрүүл мэндийн даатгал	1,194,508,700.00	1,131,678,593.79	62,830,106.21	94.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,064,993,700.00	2,682,991,683.16	382,002,016.84	87.5
Гэрэл, цахилгаан	802,303,500.00	692,186,826.68	110,116,673.32	86.3
Түлш, халаалт	1,704,551,200.00	1,563,906,861.00	140,644,339.00	91.7
Цэвэр, бохир ус	229,926,800.00	142,844,283.34	87,082,516.66	62.1
Байрны түрээс	328,212,200.00	284,053,712.14	44,158,487.86	86.5
Хангамж, бараа материалын зардал	1,533,623,100.00	1,234,402,947.57	299,220,152.43	80.5
Бичиг хэрэг	241,110,800.00	183,374,156.00	57,736,644.00	76.1
Тээвэр, шатахуун	735,328,200.00	614,815,392.56	120,512,807.44	83.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	247,198,600.00	205,150,730.51	42,047,869.49	83.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,875,100.00	14,270,022.50	15,605,077.50	47.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	280,110,400.00	216,792,646.00	63,317,754.00	77.4
Нормативт зардал	18,844,832,400.00	5,305,677,686.39	13,539,154,713.61	28.2
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,828,150,500.00	5,295,772,902.39	13,532,377,597.61	28.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,681,900.00	9,904,784.00	6,777,116.00	59.4
Эд хогшил, урсгал засварын зардал	2,926,292,200.00	2,566,952,883.94	359,339,316.06	87.7
Багаж, техник, хэрэгсэл	1,067,811,800.00	934,439,177.60	133,372,622.40	87.5
Тавилга	50,584,200.00	48,372,130.00	2,212,070.00	95.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	507,565,900.00	456,575,330.00	50,990,570.00	90.0
Урсгал засвар	1,300,330,300.00	1,127,566,246.34	172,764,053.66	86.7
Томилолт, зочны зардал	1,407,818,400.00	1,228,410,245.20	179,408,154.80	87.3
Гадаад албан томилолт	24,634,400.00	24,634,371.20	28.80	100.0
Дотоод албан томилолт	1,383,184,000.00	1,203,775,874.00	179,408,126.00	87.0

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,265,113,900.00	64,157,315,982.63	25,107,797,917.37	71.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,255,249,200.00	63,506,969,976.93	24,748,279,223.07	72.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	52,932,700.00	18,369,000.00	34,563,700.00	34.7
Даатгалын үйлчилгээ	98,323,300.00	55,092,584.50	43,230,715.50	56.0
Тээврийн хэрэгслийн татвар	89,592,700.00	58,147,247.60	31,445,452.40	64.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,700,500.00	3,349,640.00	13,350,860.00	20.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	668,016,500.00	463,497,827.60	204,518,672.40	69.4
Газрын төлбөр	84,299,000.00	51,889,706.00	32,409,294.00	61.6
Бараа үйлчилгээний бусад зардал	7,707,611,200.00	3,802,914,491.68	3,904,696,708.32	49.3
Бараа үйлчилгээний бусад зардал	7,605,040,600.00	3,725,578,580.68	3,879,462,019.32	49.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	102,570,600.00	77,335,911.00	25,234,689.00	75.4
ТАТААС	420,659,022,900.00	244,365,605,109.29	176,293,417,790.71	58.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	420,659,022,900.00	244,365,605,109.29	176,293,417,790.71	58.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	420,659,022,900.00	244,365,605,109.29	176,293,417,790.71	58.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,325,581,000.00	5,212,147,206.49	1,113,433,793.51	82.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	619,084,100.00	267,298,362.64	351,785,737.36	43.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	619,084,100.00	267,298,362.64	351,785,737.36	43.2
Бусад урсгал шилжүүлэг	5,706,496,900.00	4,944,848,843.85	761,648,056.15	86.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	249,318,100.00	102,217,650.00	147,100,450.00	41.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,980,012,000.00	2,960,512,800.00	19,499,200.00	99.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,280,635,600.00	1,064,175,302.90	216,460,297.10	83.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,016,006,800.00	738,553,790.95	277,453,009.05	72.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,524,400.00	79,389,300.00	101,135,100.00	44.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,284,200,000.00	45,509,170,848.00	10,775,029,152.00	80.9
Барилга байгууламж	48,546,700,000.00	37,777,069,221.00	10,769,630,779.00	77.8
Их засвар	502,300,000.00	499,472,070.00	2,827,930.00	99.4
Тоног төхөөрөмж	7,235,200,000.00	7,232,629,557.00	2,570,443.00	100.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(12,478,393,600.00)	33,568,730,395.08	(46,047,123,995.08)	269
Эргэж төлөгдөх зээл	(12,478,393,600.00)	33,568,730,395.08	(46,047,123,995.08)	269
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	62,478,393,600.00	15,629,079,552.52	46,849,314,047.48	25.0
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(62,478,393,600.00)	(15,629,079,552.52)	(46,849,314,047.48)	25.0
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(62,478,393,600.00)	(15,629,079,552.52)	(46,849,314,047.48)	25.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,373,631,357.45	(34,373,631,357.45)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	37,993,226,924.10	(37,993,226,924.10)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	52	52	-	100.0
Төсвийн байгууллага	52	52	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,930	1,803	338	93.4
Удирдах ажилтан	69	69	-	100.0

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гүйцэтгэх ажилтан	1,695	1,577	118	93.0
Үйлчлэх ажилтан	166	171	5	103.0
Гэрээт ажилтан	-	4	(4)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,139,732,318.30
Татварын бус орлого	31,139,732,318.30
Тусламжийн орлого	31,139,732,318.30
Хандив тусламж /дотоод/	31,139,732,318.30
Нэмэлт санхүүжилтийн орлого	31,139,732,318.30
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	612,202,839.89
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,905,719,997.43
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,654,878,581.88
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,966,930,899.10
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,806,538,700.16
УРСГАЛ ЗАРДАЛ	28,751,072,473.16
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,745,522,473.16
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,540,998,452.47
Үндсэн цалин	201,532,154.18
Нэмэгдэл	1,960,520,103.17
Урамшуулал	332,338,279.07
Гэрээт ажлын хөлс	46,607,916.05
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	336,113,811.43
Тэтгэврийн даатгал	263,523,016.15
Тэтгэмжийн даатгал	17,395,303.83
ҮОМШӨ-ний даатгал	14,271,445.79
Ажилгүйдлийн даатгал	7,466,698.82
Эрүүл мэндийн даатгал	33,457,346.84
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,343,372.38
Гэрэл, цахилгаан	5,792,772.38
Түлш, халаалт	1,550,600.00
Хангамж, бараа материалын зардал	311,174,808.86
Бичиг хэрэг	18,324,038.00
Тээвэр, шатахуун	251,287,536.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,936,698.86
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,626,536.00
Нормативт зардал	3,472,965,743.20
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,427,500,443.20
Хоол, хүнс	45,465,300.00
Эд хогшил, урсгал засварын зардал	615,352,860.00
Багаж, техник, хэрэгсэл	429,802,836.00
Тавилга	56,790,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	58,786,600.00
Урсгал засвар	69,973,424.00
Томилолт, зочны зардал	235,249,295.11
Гадаад албан томилолт	49,576,120.00
Дотоод албан томилолт	185,673,175.11
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,557,911,588.67
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,557,911,588.67

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал		668,772,541.04
Бараа үйлчилгээний бусад зардал		611,831,771.04
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		56,940,770.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,550,000.00
Бусад урсгал шилжүүлэг		5,550,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,550,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		55,466,227.00
Дотоод эх үүсвэрээр		55,466,227.00
Их засвар		55,466,227.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		2,333,193,618.14
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(2,333,193,618.14)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(2,333,193,618.14)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд /цаашид ХХААХҮС гэх/ -ын эрхлэх асуудлын хүрээнд дараах бодлогын асуудлууд хамаарч байна. Үүнд:

- Хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- Хүнсний аюулгүй байдлын асуудал;
- Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- Мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
- Бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- Мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- Малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;
- Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал;
- Жижиг, дунд үйлдвэрийн асуудал;
- Дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;
- Үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал;
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
- Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус яам нь тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 8 үндсэн стратегийн тэргүүлэх чиглэлийн зорилтыг тодорхойлж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг урт хугацааны бодлого, “Хүнсний хангамж аюулгүй байдал”, “Атар-4 аян”, “Шинэ хоршоочинээлэг малчин хөдөлгөөн”, “Цагаан алт” Монгол Улсын Засгийн Газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны бодлогууд тус тус хэрэгжиж байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон МАА-н 7, мал эмнэлгийн 2, газар тариалангийн 5, Хүнсний үйлдвэрлэлийн 9, хөнгөн үйлдвэрлэлийн 2, жижиг, дунд, үйлчилгээ, хоршооны 2 зэрэг, салбарын голлох 27 хууль, нийтлэг мөрдөгдөх 54 хууль болон

УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр, бусад холбогдох эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагч /цаашид ТЕЗ гэх/-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Малчны тухай хууль;
- Монгол улсын засгийн газрын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль;
- Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Хог хаягдлын тухай хууль;
- Усны тухай хууль;
- Органик бүтээгдэхүүний тухай зэрэг хуулиудад өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн байна.
- Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 73 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 47 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 48 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 66 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай” 69 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 96 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 108 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай” 166 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай” 190 дугаар тогтоол;

- Засгийн Газрын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол;
- МУЕС-ын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал;

ТЕЗ-ийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үнэллээ.

ТЕЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар ТЕЗ-ийн эрсдэлд суурилсан “Дотоод аудитын 2024-2026 оны дунд хугацааны төлөвлөгөө”-г, хоёрдугаар хавсралтаар “Дотоод аудит 2027-2028 оны дунд хугацааны төлөвлөгөөний төсөөлөл”-ийг тус тус баталсан байна.

Дотоод аудитын хорооны тогтоолоор баталсан “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө”-г үндэслэн ХХААХҮС-ын 2025 оны А/67 дугаар тушаалаар “Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөө”-г, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/61 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

Тайлант онд “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын хүрээнд” төлөвлөгөөт 2 дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, “Дотоод хяналт шалгалтын хүрээнд” төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 13 дотоод хяналт шалгалтыг тус тус хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,226.9 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	329,154.1	308,452.6	(20,701.5)
Авлага	588,701.3	610,439.4	21,738.1
Урьдчилгаа	7,170.5	5,744.7	(1,425.8)
Бараа материал	85,442.0	80,491.7	(4,950.3)
Нөөцийн бараа	101,355.5	118,000.4	16,644.9
Бусад эргэлтийн хөрөнгө	73,390.8	75,321.6	1,930.8
Урт хугацаат зээл	35,000.0	30,000.0	(5,000.0)
Үндсэн хөрөнгө	219,888.7	243,879.4	23,990.7
Нийт хөрөнгө	1,440,102.9	1,472,329.8	32,226.9
Нийт өр төлбөр	788,793.9	908,079.4	119,285.5
Богино хугацаат өр төлбөр	131,742.3	272,662.5	140,920.2
Урт хугацаат өр төлбөр	657,051.6	635,416.9	(21,634.7)
Засгийн газрын хувь оролцоо	651,309.0	564,250.4	(87,058.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	1,440,102.9	1,472,329.8	32,226.9

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад авлага, нөөцийн бараа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр данс өсөлттэй, мөнгөн хөрөнгө, бараа материал, урт хугацаат зээл, засгийн газрын хувь оролцоо данс бууралттай, өмнөх оноос нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Нийт хөрөнгийн 81.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 18.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 308,452.6 сая төгрөг болж, өмнөх оноос 20,701.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	1.8	1.3	(0.5)
Төгрөг	1.8	1.3	(0.5)
Банкинд байгаа бэлэн мөнгө	327,792.3	307,091.3	(20,701.0)
Төгрөг	315,207.4	305,817.0	9,390.4
Төрийн сангийн харилцах	38,091.7	19,428.9	(18,662.8)
Монгол банкин дахь харилцах	14,948.4	12,377.9	(2,570.5)
Арилжааны банк дахь харилцах	261,709.5	274,010.2	12,300.7
Нэмэлт санхүүжилтийн харилцах	457.8	0	(457.8)
Гадаад валют	12,584.9	1,274.3	(11,310.6)
Монголбанк дахь харилцах	954.5	992.6	38.1
Арилжааны банк дахь харилцах	11,630.4	281.7	(11,348.7)
Хадгаламж	1,360.0	1,360.0	-
Дүн	329,154.1	308,452.6	(20,701.5)

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 20,701.5 сая төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагын төрийн сангийн харилцах 18,662.8 сая төгрөг, гадаад валютын арилжааны банкны харилцах 11,348.7 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна. Энэ нь Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины худалдан авалтын төлбөрийг ОХУ-ын улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж гүйлгээ буцсаныг тайлант онд төлж барагдуулсантай холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1.1 хувь буюу 3,452.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 12.2 хувь буюу 37,494.8 сая төгрөгийг төсөл сангийн, 86.7 хувь буюу 267,703.3 сая төгрөгийн үлдэгдлийг төрийн өмчит компанийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Төрийн сангийн харилцахын үлдэгдэлд ЖДҮХС-ийн 15,976.6 сая төгрөг, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтын техник хяналт, барьцаа дансны 3,452.3 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Монголбанк дахь харилцах дансны үлдэгдэлд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчны хамгаалах хоёр үе шаттай төслийн 12,377.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Хадгаламжийн үлдэгдэлд АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” МОН-3288, 3287 төслийн зээлийн гэрээний хүрээнд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны авлагатай холбоотой “Ипотекийн зээлээр баталгаажсан бондоор төлбөр барагдуулах гэрээ”-ний дагуу ҮЦТХТ-өөс ҮХОБ-ны эзэмшлийн нийт 13,600 ширхэг бондыг, төсөл хаагдсантай холбогдуулан ХХААХҮЯ-нд шилжүүлсэн 1,360.0 сая төгрөг байршиж байна.

Арилжааны банкн дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэлд Зээлийн батлан даалтын сангийн 262,037.7 сая төгрөг, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгжийн 6,589.9 сая төгрөг, Биокомбинат ТӨХХК-ийн 403.4 сая төгрөг, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2,015.9 сая төгрөг, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолборын 160.5 сая төгрөг, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-ийн 2,802.6 сая төгрөгийн үлдэгдэл, гадаад валютаарх үлдэгдэлд Зээлийн батлан даалтын сангийн 275.8 сая төгрөг, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 5.8 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төслийн 992.6 сая төгрөгийн үлдэгдэл тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Томилолтын зардал зөрүүтэй тооцож олгосон, ангилал зөрүүлж шилжүүлсэн, бөөн дүнгээр нэг хүн рүү шилжүүлсэн, хоол унааны мөнгө давхардуулан олгосон 602.9 сая төгрөг; /МЭЕГ 527.5 сая төгрөг, УМЭАЦТЛ 28.2 сая төгрөг, ХХААХҮЯ 20.2 сая төгрөг, ХААБ 11.3 сая төгрөг, ЗБДС 6.4 сая төгрөг, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК 4.9 сая төгрөг, Завхан аймгийн МЭГ 2.9 сая төгрөг, ЖДҮГ 1.5 сая төгрөг/*
- *Төсвийг зохистой удирдаагүйгээс газрын төлбөр, байр ашиглалтын зардалд төлбөр төлсөн, он дамжуулан гэрээ байгуулж төлбөр шилжүүлсэн, үргүй зардал гаргасан 521.7 сая төгрөг; /ХХААХҮЯ 280.2 сая төгрөг, МЭЕГ 195.6 сая төгрөг, Төв аймгийн МЭГ 19.6 сая төгрөг, ЖДҮГ 19.3 сая төгрөг, Нийслэлийн МЭГ 7.0 сая төгрөг/*
- *Анхан шатны баримтын бүрдэл дутуу, Илүү цагийн хөлс үндэслэл тооцоогүй олгосон 333.4 сая төгрөг; /ЖДҮГ 184.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ХХААГ 43.5 сая төгрөг, Төв аймгийн ХХААГ 36.5 сая төгрөг, Булган аймгийн МЭГ 32,8 сая төгрөг, Архангай аймгийн МЭГ 19.5 сая төгрөг, Говь-Алтайн аймгийн ХХААГ 9.4 сая төгрөг, Орхон аймгийн МЭГ 5.2 сая төгрөг, Халх гол бүтээн байгуулалтын бүс 2.0 сая төгрөг/*

- НДШ-ийн тайлан зөрүүтэй тайлагнасан, цалин давхардуулан олгосон, цалин зөрүүтэй тооцон олгосон, ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон 103.3 сая төгрөг /Малын удмын сангийн үндэсний төв 84.4 сая төгрөг, Дорноговь аймгийн МЭГ 13.3 сая төгрөг, МЭЭСБУЛ 4.0 сая төгрөг, Дорнод аймгийн ХХААГ 1.6 сая төгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 610,439.4 сая төгрөг болж, өмнөх оноос 21,738.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	73.2	101.4	28.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	18,370.9	10,686.2	(7,684.7)
Татаас, санхүүжилтийн авлага	1,742.7	14,270.7	12,528.0
Зээлийн хүүгийн авлага	31.8	3.3	(28.5)
Дансны авлага /ТӨҮГ/	2,218.2	2,567.5	349.3
Бусад авлага	8,439.5	20,880.3	12,440.8
Байгууллагаас авах авлага	7,004.7	19,067.2	12,062.5
Хувь хүмүүсээс авах авлага	1,434.8	1,813.1	378.3
Зээлийн авлага	557,825.1	561,930.0	4,104.9
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	557,825.1	561,930.0	4,104.9
Дүн	588,701.4	610,439.4	21,738.0

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 610,439.4 сая төгрөгийн үлдэгдэлд төсөвт байгууллагын 5.0 хувь буюу 30,612.4 сая төгрөг, төсөл, сангийн 60.3 хувь буюу 368,566.2 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газрын 34.5 хувь буюу 211,063.0 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Нийт авлагын 92.0 хувийг зээлийн, 1.7 хувийг төлбөртэй үйлчилгээний, 2.3 хувийг татаас санхүүжилтийн авлага, 4 хувийг бусад авлага тус тус эзэлж байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 21,738.0 сая төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 12,528.0 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 11,864.7 сая төгрөгөөр нэмэгдэж, төлбөртэй үйлчилгээний авлага 7,684.7 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөө үзүүлсэн байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага дансны үлдэгдэлд ЗБДС-ийн хуримтлуулан бүртгэсэн хадгаламжийн хүүгийн авлага 10,627.1 сая төгрөг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 59.1 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэл ХХААХҮЯ-ны Хөтөлбөр арга хэмжээний дансны 1,251.4 сая төгрөг, ХХААХҮЯ-ны аппаратын 4 орон сууцны санхүүжилтийн 1,077.6 сая төгрөг, Мал эмнэлгийн ерөнхий газрын үйлчилгээний хөлс 11,540.2 сая төгрөг, бусад байгууллагын 401.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлагын үлдэгдэлд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн 193,969.8 сая төгрөг, ЖДҮХС-ийн 241,075.3 сая төгрөг, ЖДҮХБОХ хоёр үе шаттай зээлийн төслийн 86,138.0 сая төгрөг, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж төслийн 40,746.8 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 4,104.9 сая төгрөгөөр өссөн нь ЖДҮХС-ийн авлага 4,229.1 сая төгрөг, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн авлага 16,048.4 сая төгрөгөөр нэмэгдэж, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж төслийн

авлага 14,199.2 сая төгрөг, ЖДҮХБОХ хоёр үе шаттай төслийн авлага 1,973.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй 45,200.7 сая төгрөг; / “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 44,002.7 сая төгрөг, Малын удмын сангийн үндэсний төв 998.7 сая төгрөг, ЗБДСан 101.6 сая төгрөг, Төв аймгийн ХХААГ 64.5 сая төгрөг, Халх гол бүтээн байгуулалтын бүс 33.2 сая төгрөг/
- Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, авлагын үлдэгдлийг барагдуулаагүй 927.9 сая төгрөг; / “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 479.5 сая төгрөг, Ховд аймгийн ХХААГ 257.0 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв 61.2 сая төгрөг, МЭЕГ 44.5 сая төгрөг, Архангай аймгийн ХХААГ 38.8 сая төгрөг, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа 31.2 сая төгрөг, Говь-Алтай ХХААГ 15.7 сая төгрөг/
- “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК -ийн хүнсний улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс 3,217.2 сая, тодорхой бус өр төлбөрийн 384.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, мөн бүртгэлтэй хаяг дээрээ байхгүй харилцагчийн 4,123.8 сая төгрөг, татан буугдсан харилцагчийн 633.1 сая төгрөг, эзэн холбогдогч нь нас барсан 80 харилцагчийн 388.9 сая төгрөгийн авлагуудыг ТУЗ-өөр шийдвэрлүүлээгүй авлагын үлдэгдэлтэй хэвээр байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 5,744.7 сая төгрөг болж, 1,425.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	7,170.5	5,744.7	(1,425.8)
Дүн	7,170.5	5,744.7	(1,425.8)

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2,850.8 сая төгрөг, ЗБДС-ийн АХБ-ны төслийн зээлийн 2016-2017 онд үүссэн хүү, амлалтын шимтгэлийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн 2,612.8 сая төгрөг, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтын цуцлагдсан гэрээт ажлын урьдчилгаа 224.2 сая төгрөг, бусад харьяа 5 байгууллагын 193.1 сая төгрөгийн ажил, үйлчилгээний урьдчилгаа тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ямааны арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 66.2 сая төгрөгийг төлөөгүйгээс 43.8 сая төгрөгийн алданги, химийн агуулахын барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 64.4 сая төгрөгийг төлөөгүйгээс алданги 40.1 сая төгрөгийн алданги, нийт 84.0 сая төгрөгийн алдангийг “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-аас төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсныг өглөгөөр бүртгэж урьдчилж гарсан зардалд бүртгэсэн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 80,491.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,950.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	41,150.9	43,996.5	2,845.6
Тусгай зориулалттай материал	19,620.8	28,176.5	8,555.7
Эм боох материал	21,530.1	15,820.0	5,710.1
Дуусаагүй үйлдвэрлэл	3,935.2	4,102.8	167.6
Бэлэн бүтээгдэхүүн	6,091.3	5,589.2	(502.1)
Хангамжийн материал	23,307.6	25,990.5	2,682.9
Бичиг хэргийн материал	357.8	392.1	34.3
Аж ахуйн материал	2,099.4	2,475.1	375.7
Сэлбэг хэрэгсэл	643.1	763.1	120.0
Түлш, шатах тослох материал	358.7	654.8	296.1
Барилгын засварын материал	121.8	125.8	4.0
Хүнсний материал	82.3	161.0	78.7
Бусад хангамжийн материал	19,644.5	21,418.6	1,774.1
Биологийн хөрөнгө	43.5	152.9	109.4
Мал амьтад	10,913.5	659.8	(10,253.7)
Дүн	85,442.0	80,491.7	4,950.3

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд төсөвт байгууллагын 52,478.5 сая төгрөг, төсөл, сангийн 14,012.5 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газрын 14,000.7 сая төгрөгийн бараа материал тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдлийн 54.7 хувийг түүхий эд материал, 5.1 хувийг дуусаагүй үйлдвэрлэл, 6.9 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 32.3 хувийг хангамжийн материал, 1.0 хувийг мал амьтад тус тус эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 4,950.3 сая төгрөгөөр буурахад Малын удмын сангийн үндэсний төвийн мал амьтад дансны үлдэгдэл 10,257.1 сая төгрөгийг биологийн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Их хэмжээний бараа материал нөөцөлсөн, хугацаа дууссан бараа материал байршиж байна 1,358.0 сая төгрөг; /ХААК ТӨХХК 941.0 сая төгрөг, МЭЕГ 349.3 сая төгрөг, ЗБДС 65.4 сая төгрөг, Ховд аймгийн МЭГ 2.3 сая төгрөг/
- Бараа материалын тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээг бүртгэсэн 74.8 сая төгрөг; /Говьсүмбэр аймгийн МЭГ 43.5 сая төгрөг, Хэнтий аймгийн ХХААГ 20.0 сая төгрөг, Булган аймгийн МЭГ 8.4 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн МЭГ 1.5 сая төгрөг, Архангай аймгийн ХХААГ 1.4 сая төгрөг/
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, шууд зардалд бүртгэсэн, үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан 64.1 сая төгрөг; /ХААК ТӨХХК 44.3 сая төгрөг, Орхон аймгийн ХХААГ 17.9 сая төгрөг, Сүхбаатар МЭГ 1.9 сая төгрөг /
- ЖДҮХС-ийн бэлэн бүтээгдэхүүн дансанд "санхүүгийн түрээс"-ээр худалдах зорилготой 62.8 сая төгрөгийн өртөг бүхий 1-ээс дээш жилийн насжилттай тоног төхөөрөмжүүдийг эргэлтэд оруулаагүй бараа материалд бүртгэлтэй хэвээр байна;

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 76,175.3 сая төгрөг болж, өмнөх оноос 25,180.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нөөцийн бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	187.7	400.1	212.4
Үрийн нөөц	10,734.6	14,985.2	4,250.6
Тэжээлийн нөөц	818.3	2,116.9	1,298.6
Шатахууны нөөц	136.0	307.3	171.3
Буудайн нөөц	73,708.2	44,512.2	(29,195.8)
Бусад нөөц	15,770.7	13,853.6	(1,917.1)
Дүн	101,355.5	76,175.3	(25,180.2)

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэл 76,175.3 сая төгрөг болж, өмнөх оноос 25,180.5 сая төгрөгөөр буурсан нь ургацын гарц муу байсан, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн худалдан авалт нэмэгдэж, борлуулалт нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Нөөцийн барааны үлдэгдэлд төсөвт байгууллагын 2,252.7 сая төгрөг, төрийн өмчит хуулийн этгээдийн 73,922.6 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн нөөцийн үлдэгдэлд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн хүнсний улаанбуудайн 44,512.2 сая төгрөгийн 35,338.9 тн, үрийн 14,724.4 сая төгрөгийн 4,496.2 тн, тэжээлийн буудайн 1,633.9 сая төгрөгийн 1,856.7 тн нөөц, дамжуулан зээлийн болон өөрийн эх үүсвэрээр БНХАУ, ОХУ, БНБУ, Польш зэрэг улсаас нийлүүлсэн ХАА-н 9,109.4 сая төгрөгийн техник төхөөрөмж бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн хөрөнгийн тооллогоор үүссэн 402.5 сая төгрөгийн 423.64 тонн хэмжээтэй будааны дутагдлыг шийдвэрлээгүй байна;
- Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь 2024 онд зөвшөөрөлгүй нийлүүлсэн 45.7 сая төгрөгийн, 65.29 тн будааг борлуулалтаар тусгаагүй, биетээр оршин байхгүй нь 2025 оны эхний хагас жилийн тооллогоор илэрсэн боловч буудайны дансанд бүртгэлтэй хэвээрээ, зохих арга хэмжээг авч ажиллаагүй байна;

3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 117,146.7 сая төгрөг болж, өмнөх оноос 43,755.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	73,390.8	116,084.8	42,694.0
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		1,061.9	1,061.9
Дүн	73,390.8	117,146.7	43,755.9

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн 93,304.1 сая төгрөгийн ажил, Жижиг дунд үйлдвэрийн газрын хугацаа хэтэрсэн авлагад суутган тооцож хүлээн авсан борлуулах зориулалт бүхий 22,268.4 сая төгрөгийн хөрөнгө, Зээлийн батлан даалтын сангийн 512.2 сая төгрөг, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 1,061.9 сая төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ЖДҮХС-ийн тайланд зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 22,368.4 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаа зохион байгуулсан боловч сонирхогч этгээд оролцоогүй, ашиглалтын нэмэлт зардал гарсан хэвээр байна.

3.4.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл 35,000.0 сая төгрөг болж, өмнөх оноос 5,000.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	35,000.0	30,000.0	(5,000.0)
Дүн	35,000.0	30,000.0	(5,000.0)

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний дагуу Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоол, Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2021 оны 131 дүгээр тогтоол, Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх” 2021 оны 12/02-02 дугаар гэрээний дагуу “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг банкуудын эх үүсвэрт тулгуурлан олгох, зээлд хамрагдахаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд батлан даалт гаргах ажлын хүрээнд Зээлийн батлан даалтын сан нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 50,000.0 сая төгрөгийн үнэт цаасыг хаалттай хүрээнд гаргасан байна.

Дээрх 4 талт гэрээний дагуу Хадгаламжийн даатгалын корпораци нь Зээлийн батлан даалтын сангийн гаргасан үнэт цаасыг жил бүр тэнцүү хэмжээгээр худалдан авах бөгөөд тайлант оны 5,000.0 сая төгрөгийн зарцуулалтын дүнгээр буурсан байна.

3.4.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 243,879.4 сая төгрөг болж, өмнөх оноос 23,990.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	171,101.1	181,194.8	10,093.7
Барилга, байгууламж, орон сууц	120,744.3	125,369.3	4,625.0
Авто-тээврийн хэрэгсэл	11,988.3	12,367.7	379.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	20,146.9	22,675.4	2,528.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,730.0	4,167.2	1,437.2
Зам, гүүрийн байгууламж	3,152.1	3,173.5	21.4
Бусад үндсэн хөрөнгө	6,530.3	7,632.5	1,102.2
Дуусаагүй барилга, байгууламж	5,809.1	5,809.1	-
Ном	0.1	0.1	-
Биет бус хөрөнгө	48,787.6	49,171.1	383.5
Программ хангамж	1,799.0	1,959.4	160.4
Бусад биет бус хөрөнгө	46,988.6	47,211.7	223.1
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	-	13,513.5	13,513.5
Дүн	219,888.7	243,879.4	23,990.7

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн

нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд төсөвт байгууллагын 147,236.2 сая төгрөг, төсөл, сангийн 290.9 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газрын 96,352.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд 74.3 хувь буюу 181,194.8 сая төгрөгийн биет хөрөнгө, 20.2 хувь буюу 49,171.1 сая төгрөгийн биет бус, 5.5 хувь буюу 13,513.5 сая төгрөгийн биологийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 23,990.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Биокомбинат ТӨХХК лабораторийн барилгын их засвар, МААЭЗЭНТ-өөс шилжиж ирсэн хөрөнгө, ТӨБЗГ-ын 2025 оны 409, 725 дугаар тогтоолуудаар балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгө, ХХААХҮС-ын 2025 оны А/343 тушаалаар шилжиж ирсэн хөрөнгө, өөрийн хөрөнгөөр худалдан авсан төхөөрөмж гэх мэт нийт 1,503.2 сая төгрөг, Малын Удмын сангийн үндэсний төв Мал амьтад дансны үлдэгдлийг биологийн хөрөнгө дансруу шилжүүлсэн 10,257.1 сая төгрөг, Төв аймгийн ХХААГ тариалангийн тоног төхөөрөмжийг “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 1,298.8 сая төгрөг, Говьсүмбэр ХХААГ шинэ конторын барилга, газар автомашин зэрэг хөрөнгө 1,130.3 сая төгрөг, Дорноговь аймгийн МЭГ Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн лабораторийн барилга 2,504.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн МЭГ Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын стандартад нийцсэн мал эмнэлгийн итгэмжлэгдсэн биоаюулгүйн 2 дугаар зэрэглэлийн лабораторийг ашиглалтад хүлээн авсан 3,016.6 сая төгрөг зэрэг нь голлон нөлөөлж байна.

Тодруулга тайлангаар үндсэн хөрөнгө худалдан авсан 3,481.9 сая төгрөг, хандиваар 847.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн хүлээн авсан 14,862.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээр нэмэгдсэн 23,847.1 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1,254.8 сая төгрөг, нийт 44,293.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдан борлуулсан 3.5 сая төгрөг, ТӨБЗГ-ын шийдвэрээр акталж данснаас хассан 1,400.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 2,388.8 сая төгрөг, бусад 7,834.0 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 1,097.9 сая төгрөг, нийт 12,724.7 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй 360.5 сая төгрөг; /ЗБДС 301.2 сая төгрөг, Булган аймгийн МЭГ 46.5 сая төгрөг, ХААК ТӨХК 12.8 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ХХААГ, Нийслэлийн МЭГ, Малын удмын сангийн үндэсний төв /
- Үндсэн хөрөнгө орлогодоогүй 268.1 сая төгрөг /Сэлэнгэ аймгийн ХХААГ 123.6 сая төгрөг, Биокомбинат 87.8 сая төгрөг, ХХААХҮЯ 44.6 сая төгрөг, Ховд аймгийн ХХААГ 12.1 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн тооллого, тооцоо бүрэн хийгээгүй, элэгдлийн зардал зөрүүтэй тооцоолсон 97.6 сая төгрөг /Нийслэлийн МЭГ, Баянхонгор аймгийн МЭГ, УМЭАЦТЛ, Халх гол бүтээн байгуулалтын бүс 97.6 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн 26.8 сая төгрөг /МЭЭГ 19.2 сая төгрөг, Малын удмын сангийн үндэсний төв 7.6 сая төгрөг/
- Акталсан хөрөнгийн талаарх журмын хэрэгжилт хангалтгүй /МЭЭГ/

3.4.9 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 908,462.5 сая төгрөг болж, өмнөх оноос 119,668.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	131,742.3	273,045.6	141,303.3
Богино хугацаат зээлийн өглөг	440.3	384.9	(55.4)
Төслийн зээл- гадаад валют	440.3	384.9	(55.4)
Өглөг	123,075.8	271,386.8	148,311.0
Урьдчилж орсон орлого	8,226.2	1,273.8	(6,952.4)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	657,051.6	635,416.9	21,634.7
Урт хугацаат зээл	657,051.6	635,416.9	21,634.7
Төгрөг	226,900.3	226,695.1	205.2
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	166,248.9	164,964.7	(1,284.2)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	35,050.0	30,050.0	(5,000.0)
Санхүүгийн бусад байгууллага	22,111.4	28,063.4	5,952.0
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	3,490.0	3,617.0	127.0
Гадаад валют	430,151.3	408,721.8	(21,429.5)
Төслийн зээл	430,151.3	408,721.8	(21,429.5)
Дүн	788,793.9	908,462.5	119,668.6

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдэлд төсөвт байгууллагын өр төлбөр 21.1 хувь буюу 191,886.5 сая төгрөг, төсөл, сангийн өр төлбөр 30.2 хувь буюу 273,807.7 сая төгрөг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр 48.7 хувь буюу 442,768.3 сая төгрөг байна.

Нийт өр төлбөрийн 30.0 хувь буюу 273,045.6 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр, 70.0 хувь буюу 635,416.9 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн 273,045.6 сая төгрөгийн үлдэгдэлд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 77,193.4 сая төгрөг, МЭЕГ-ын 21,582.0 сая төгрөг, ХХААХҮЯ-ны Хөрөнгө оруулалтын барьцаа дансны 2,746.6 сая төгрөг, Хөтөлбөр, арга хэмжээний зардлын 144,105.8 сая төгрөг, ЗБДС-ийн 562.5 сая төгрөг, Биокомбинат ТӨҮГ-ын 1,064.0 сая төгрөг, ХААБ 577.6 сая төгрөг, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 1,112.0 сая төгрөг, бусад харьяа 54 байгууллагын 24,101.7 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Дансны ангиллаар авч үзэхэд богино хугацаат өр төлбөрийн 88.4 хувь буюу 241,394.9 сая төгрөг нь байгууллагад төлөх өр төлбөр, 9.3 хувь буюу 25,477.4 сая төгрөг нь зээлийн хүүгийн өр төлбөр, 0.4 хувь буюу 1,114.9 сая төгрөг нь дансны өр төлбөр, 1.9 хувь буюу 5,058.4 сая төгрөг нь бусад өр төлбөрийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 141,303.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ХХААХҮЯ-ны Хөтөлбөр арга хэмжээ дансны өр төлбөр 142,873.9 сая төгрөг, Мал эмнэлгийн ерөнхий газрын өр төлбөр 10,066.0 сая төгрөг, ХААБ 169.3 сая төгрөг ХХААХҮЯ-ны аппарат 893.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн өр төлбөр 410.8 сая төгрөг, ЗБДС-ийн өр төлбөр 5,425.7 сая төгрөг, Биокомбинат ТӨХХК-ийн 883.6 сая төгрөг, ХХААХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, их засвар дансны өр төлбөр 6,835.1 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлж байна.

Урт хугацаат зээлийн 635,416.8 сая төгрөгийн үлдэгдэлд ЖДҮХБО-ыг хамгаалах хоёр үе шаттай төслийн 139,011.7 сая төгрөг, Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил нэгжийн 106,067.5 сая төгрөг, ЗБДС-ийн 194,999.2 сая төгрөг, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн 163,642.5 сая төгрөг, ХХАА, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн Дулааны үр

ашгийн төслийн хүрээнд барилга байгууламжид суурилуулсан төвлөрсөн дулаан хангамжийн тоног төхөөрөмжийн 15.5 сая төгрөг, Биокомбинат ТӨХХК-ийн 3,617.0 сая төгрөг, ЖДҮХС-ийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох зориулалтаар Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл, Өмнөговь, Дархан-Уул, Сүхбаатар, Завхан зэрэг аймгаас авсан эх үүсвэр 28,063.4 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Урт хугацаат зээлийн үлдэгдэл өмнөх оноос 21,634.7 сая төгрөгөөр буурсан нь Зээлийн батлан даалтын сан нь Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн 4 талт гэрээний графикт төлбөрийг Хадгаламжийн даатгалын корпорацад төлсөн 5,000.0 сая төгрөг төлсөн, ЖДҮХС нь хөнгөлөлттэй зээл олгох зориулалтаар Өмнөговь аймгийн ЗДТГ-аас 3,285.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Ховд аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Орхон аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Завхан аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Дундговь аймгийн ЗДТГ-аас 400.0 сая төгрөг, Дорнод аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Говь-Сүмбэр аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас 100.0 сая төгрөг, Архангай аймгийн ЗДТГ-аас 150.0 сая төгрөг нийт 6,635.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан, Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК БНХАУ-ын ЗГ-ын, БНБУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлсэн зээлийн үндсэн төлбөрийг 5,840.0 сая төгрөгөөр бууруулсан, ХХАА, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв 2.5 сая төгрөгийн зээл төлсөн зэргээс голлон нөлөөлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай өр төлбөрийг барагдуулаагүй, төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэсэн, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг 101,612.8 сая төгрөг; / “Хөдөө аж ахуйн корпорац ” ТӨХХК нь 86,987.2 сая төгрөг, МЭЕГ 13,913.6 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ХХААГ 511.8 сая төгрөг, Сүхбаатар МЭГ 81.2 сая төгрөг, Биокомбинат 32.1 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв 24.2 сая төгрөг, Орхон аймгийн ХХААГ 19.7 сая төгрөг, Төв аймгийн ХХААГ 15.5 сая төгрөг, Малын удмын сангийн үндэсний төв 13.8 сая төгрөг, ХХААХҮЯ 8.0 сая төгрөг, Өмнөговь МЭГ 4.5 сая төгрөг, МЭЕГ 1.2 сая төгрөг/ ;
- ЖДҮХС-д зээлийн ангилал зөрүүлсэн 30.4 сая төгрөг.

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 563,867.3 сая төгрөг болж, өмнөх оноос 87,441.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	137,931.1	144,081.1	6,150.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	93,094.0	94,578.9	1,484.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0.01	0.01	0.0
Хуримтлагдсан үр дүн	381,647.2	285,959.9	(95,687.3)
Өмнөх үеийн үр дүн	258,686.0	372,959.9	114,273.9
Тайлант үеийн үр дүн	122,961.2	(87000.0)	(209,961.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,636.7	39,247.4	610.7
Дүн	651,309.0	563,867.3	87,441.7

Эх сурвалж: ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 6,150.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ЗБДС-ийн 6,160.0 сая төгрөгөөр нэмэгдэж, Хөвсгөл аймгийн ХХААГ ТӨБЗГ-ын 2025 оны А-1/223 албан бичгийн дагуу Биет бус хөрөнгө дансанд бүртгэлтэй Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 5001м/кв 10.0 сая төгрөгийн газрын эзэмших эрхийг Засаг даргын 2025 оны А/122 дугаар захирамжаар дуусгавар болгож, нийтийн эзэмшилд шилжүүлж бүртгэснээс тус тус шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл өмнөх оноос 95,687.3 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт харьяа 18 байгууллагад 2,099.6 сая төгрөг, өмчид гарсан өөрчлөлт харьяа 2 байгууллагад /ХААБирж, ЗБДСан/ 6,587.7 сая төгрөгөөр тус тус буурч, тайлант жилийн үр дүн 87,000.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд ХХААХҮС-ын төсвийн багцын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,803,551.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 28,610.6 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэж төлөгдөх эх үүсвэрээс (17,111.1) сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 1,850,267.7 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 644,032.6 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 341,121.4 сая төгрөгөөр бууруулж, Улсын Их Хурлаас нийт зарлага ба цэвэр зээлийг 750,524.1 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 53 арга хэмжээг санхүүжүүлэхээр 676,257.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 48,857.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэж төлөгдөх эх үүсвэрээс (62,478.4) сая төгрөгийг бүрдүүлэхээр, нийт зарлага цэвэр зээлийг 87,887.9 сая төгрөгөөр бууруулж, 662,636.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 396,136.9 сая төгрөгийн, хөрөнгийн зардалд 45,509.2 сая төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 53,416.3 сая төгрөг нийт 490,843.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, 463,348.8 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 15,327.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсвөөс 676,257.0 сая төгрөгийн санхүүжилт авахаас 64.7 хувь буюу 437,427.6 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 48,857.6 сая төгрөг бүрдүүлэхээс 53,416.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тайлант онд нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 463,348.8 сая төгрөг буюу 69.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 199,287.4 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна. Энэ нь хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага хөтөлбөрийн зардал 65,303.3 сая төгрөг, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх зардал 65,999.1 сая төгрөг, газар

тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал 46,641.4 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн 85.5 хувь буюу 396,136.9 сая төгрөгийг урсгал, 9.8 хувь буюу 45,509.2 сая төгрөгийг хөрөнгийн, 4.7 хувь буюу 21,702.7 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

Нийт урсгал зарлагын гүйцэтгэлийн 37.0 хувь буюу 146,559.2 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардал, 61.7 хувь буюу 244,365.6 сая төгрөгийг татаас санхүүжилт, 1.3 хувь буюу 5,212.1 сая төгрөгийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас санхүүжилтийн зардал 420,659.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 244,365.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 17.3 хувь буюу 42,242.8 сая төгрөгийг хүнсний улаанбуудай, хүнсний ногоо, сүү, арьс шир, ноосны урамшууллын зардалд, 82.7 хувь буюу 202,122.7 сая төгрөгийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлт болон зээлийн хүүгийн татаасны зардалд зарцуулсан байна.

Тайлант оны төсвийн тухай хуулиар ХХААХҮС-ын хөрөнгө оруулалтын төсөвт нийт 141,359.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 арга хэмжээг 56,284.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан. Үүнд: Барилга байгууламжийн 14 арга хэмжээнд 48,546.7 сая төгрөг, их засварын 3 арга хэмжээнд 502.3 сая төгрөг, тоног төхөөрөмжийн 2 арга хэмжээнд 7,235.2 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 45,509.2 сая төгрөг буюу 80.8 хувийн санхүүжилт авч эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлийн санхүүжилтэд 41,712.8 сая төгрөг, орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт 3,796.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 23,221.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 21,702.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Дотоодын эх үүсвэрээс нийт 63,000.0 сая төгрөгийн эргэж төлөгдөх зээл олгохоор төлөвлөснөөс 61,796.6 сая төгрөгийн зээл олгон 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсөвт буцаан төлөх эргэж төлөгдөх Засгийн газрын дамжуулан зээлийн төлөлтийг 58,779.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 40,093.9 сая төгрөг төвлөрүүлэн 68.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээний нэр, код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	67,365.7	41,545.1	25,820.6	61.7
70802 Газар тариалан хөгжүүлэх	102,391.8	55,750.4	46,641.4	54.4
70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	16,731.7	16,342.8	388.9	97.7
70804 Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	81,773.9	15,774.8	65,999.1	19.3
70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	288,028.1	235,333.3	52,694.8	81.7
70806 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ	858.8	496.0	362.8	57.8
70808 Шинэ хоршоо хөдөлгөөн	95,759.7	59,436.2	36,323.5	62.1
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох	9,726.6	50,536.2	(40,809.6)	519.6
Нийт дүн	662,636.3	475,214.8	187,421.4	71.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх аудитаар өгсөн төлөвлөлт сайжруулах зөвлөмж хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар батлаагүй, ТШЗ бүрээр баталгаажуулж хүргүүлээгүй, Төлөвлөлт оновчтой биш, үндсэн үйл ажиллагааны шинжтэй зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулдаг /ЗБДС, МЭЕГ, ХХААХҮЯ, Биокомбинат 400.0 сая төгрөг/;
- Санхүүгийн тайлан хугацаа хоцроож ирүүлсэн/ ЖДҮХС 30 хоног, Биокомбинат 15 хоног./
- ЖДҮХС гэрээний хугацаа дууссан боловч 21 зээлдэгчийн 1,312.7 сая төгрөгийн зээлийг зээлийн мэдээллийн санд ангилал зөрүүтэй нийлүүлсэн. Зээлийн мэдээллийн санд 223 зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан зориулалтыг буруу болон зөрүүтэй бүртгэсэн байна
- НӨАТ-ын тайлан зөрүүтэй тайлагнасан 78.5 сая /Биокомбинат/
- Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын биелэлтийн хэрэгжилт удааширч, сунжирсан/ ХХААХҮЯ/
- Төрийн албаны зөвлөлөөс өгсөн ажлын байрны ачааллыг жигдрүүлэх, чиг үүргийн шинжилгээ хийх зөвлөмж хэрэгжүүлээгүй./МЭЕГ/
- Гэрчилгээний орлогод тавих хяналт сул /МЭЕГ/
- И-баримт цахим системийн төлбөрийн баримт зөрүүтэй /ЖДҮ-ийг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл/

3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар ТЕЗ-ийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 8 хөтөлбөрийн 12 хүрэх үр дүнг баталсан байна.

Хүснэгт 13. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Гүйцэтгэл
70801 Мал аж ахуйг хөгжүүлэх						
Бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг сайжруулна.	Нийт бэлчээрт даац хэтэрсэн бэлчээрийн эзлэх хувийн жин	хувь	2023	60.0	57.5	54.4
Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Нийт мал сүрэгт цөм сүргийн эзлэх хувийн жин	хувь	2023	8.7	9.0	9.0
	Өндөр ашиг шимт малын эзлэх хувь	хувь	2023	0.5	1.0	1.0
Бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг сайжруулна.	Нийт бэлтгэсэн тэжээлийн хэмжээ /мян.тн/	тн	2023	1,604.0	1,650.0	1,800.0
Малын халдварт өвчний гаралтыг бууруулна.	Гоц халдварт өвчний голомт	тоо	2023	128.0	100.0	34.0
	Халдварт өвчний голомт	тоо	2023	685.0	648.0	430.0
70802 Газар тариаланг хөгжүүлэх						
Нэгж талбайн ургацыг нэмэгдүүлнэ.	1 га талбайгаас хураан авах улаан буудайн хэмжээ	цн/га	2023	13.2	14.0	9.6
	1 га талбайгаас хураан авах төмсний хэмжээ	цн/га	2023	92.3	120.0	85.1
	1 га талбайгаас хураан авах хүнсний ногооны хэмжээ	цн/га	2023	120.0	122.0	146.2
70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх						
Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	2023	2,123.1	2,229.3	2,838.7
	Хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	2022	149.8	159.8	239.8
	Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	2022	2.7	3.0	4.5
	Сүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	2022	936.0	937.5	260.5

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүн амын хоол, хүнсний зохистой хэрэглээг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Дотоодын баталгаажсан хүнсний органик бүтээгдэхүүний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ	хувь	2023	0.5	1.5	0.1
70804 Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх						
Хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ.	Арьс ширний гүн боловсруулалтын түвшин	хувь	2023	30.0	35.0	33.0
	Ноос, ноолуурын бүрэн боловсруулалтын түвшин	хувь	2023	20.0	25.0	25.0
	Ээрэхээс дээш түвшинд ноос, ноолуурын боловсруулалт хийх үйлдвэрийн хүчин чадал /сүлжих сая.шир/	сая.шир хэг	2023	5.3	5.8	5.8
70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн бодлого удирдлага						
Салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн хувь /өссөн дүнгээр/	хувь	2024	T	25.0	21.8
70806 Хөдөө аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн судалгаа шинжилгээ						
Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ, туршилтыг хөгжүүлнэ.	Дэмжлэг үзүүлсэн инновацын төсөл	тоо	2023	12.0	15.0	
72101 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих						
Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлд хамрагдсан аж ахуйн нэгжээр дамжуулан шинээр бий болгох ажлын байрны тоог нэмэгдүүлнэ.	Шинээр бий болгох ажлын байрны тоо	тоо	2023	1,000.0	3,000.0	2,394.0
	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж	тоо	2022	69,539.0	70,000.0	82,471.0
70808 Шинэ хоршоо хөдөлгөөн						
Хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоо	тоо	2023	25,457.0	26,000.0	24,983.0
	Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлт	хувь	-	-	10.0	23.0

Эх сурвалж: ХХААХҮЯ-СХОГ

Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрт тусгасан "Шинэ Ховд" ҮТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтын явцын хувь 92.0 хувийн хэрэгжилттэй байна.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 612.2 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 13,905.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 13,654.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,967.3 сая төгрөг, нийт 31,140.1 сая төгрөгөөр эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 28,751.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 55.5 сая төгрөгийг зарцуулж, 1,064.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 1,269.1 сая төгрөгийг авлагад тооцож төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- МУЗГ-ын 2013 оны "Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай" 250 дугаар тогтоол гарч 23,000.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2013 онд багтаан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгохыг Хөдөлмөрийн сайдад зөвшөөрсүгэй гэсэн шийдвэр гарсан. 2013.07.16-ний өдрийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 23,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг /ХЭДС-аас 17,000.0 сая төгрөг, ЖДҮХС-аас 6,000.0 сая төгрөг/ Сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдэд олгох шийдвэр гарч, зээл, зээлийн хүүг эргэн төвлөрүүлэх, зээлийн эрсдэлийг ҮХААЯ бүрэн хариуцна гэж тус гэрээнд тусгасан байна. Гэрээний хүрээнд зээл авсан гэх компаниудаас шүүхийн шийдвэрээр зээлийн эргэн төлөлтөд орж ирсэн 1,180.1 сая төгрөгийг ХЭДС-д тооцоо нийлсэн актгүйгээр төвлөрүүлсэн, тус гэрээнд заасан хамтарсан хяналтын зөвлөл хяналтаа хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 7 төсөл хэрэгжүүлэгч нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 14. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Санхүүжүүлэгч байгууллагын нэр	Төслийн нэр	Төслийн				
			Хэрэгжих хугацаа	Валют	Төсөв	Ашиглалт	Хувь
1	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	2018-2023	сая ам.доллар	9.0	8.9	98.9
2	Дэлхийн банк	Мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	2020-2025	сая ам.доллар	30.0	29.1	97.0
3	Азийн хөгжлийн банк	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл	2020-2026	сая ам.доллар	40.0	19.7	49.2
					2.0		
4	Азийн хөгжлийн банк	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь	2016-2023	сая ам.доллар	60.0	60.0	100.0

5		Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	2018-2024	сая ам.доллар	3.5	3.3	94.3
6		Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл / нэмэлт санхүүжилт /	2016-2021	сая ам.доллар	50.0	49.3	98.6
7	Жайка ОУБ	"Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл	2011-2018	тэрбум иен	5.0	5.0	100.0

Үүнээс: АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт”, Жайка ОУБ -ын “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл”-үүд хэрэгжиж дууссан ба нэмэлт санхүүжилт болон зээлийн эргэн төлөлтөөр төслийг хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгжийн төсөл хэрэгжих хугацаа дуусвар болж ТНБД-ын тушаалаар ажлын хэсэг байгуулж, ХХААХҮЯ руу холбогдох эд хөрөнгө, албан хэрэг материалыг хүлээн авахыг даалгасан байна.

3.5.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг ХХААХҮС-ын 2025 оны А/17 дугаар тушаалаар баталсан байна. Үүнд: Хөрөнгийн санхүүжилтээс 35,214.7 сая төгрөгийн 4 худалдан авалтыг, урсгал төсвийн санхүүжилтээс 38,943.7 сая төгрөгийн 61 худалтан авалтыг төлөвлөсөн байна.

ХХААХҮС-ын 2025 оны А/125, А/184, А/603 дугаар тушаалуудаар дээрх төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Төлөвлөгөөнд 43,688.2 сая төгрөгийн 45 худалдан авалтыг НТШ-аар, 2,473.1 сая төгрөгийн 35 худалдан авалтыг харьцуулалтын аргаар, 1,334.4 сая төгрөгийн 2 худалдан авалтыг ерөнхий гэрээгээр, 549.9 сая төгрөгийн 38 худалдан авалтыг шууд гэрээгээр, 4,490.4 сая төгрөгийн 3 худалдан авалтыг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар гүйцэтгэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр НТШ-ын аргаар 43,188.2 сая төгрөгийн, харьцуулалтын аргаар 2,473.1 сая төгрөгийн, ерөнхий гэрээгээр 1,334.4 сая төгрөгийн, гэрээ шууд байгуулах аргаар 549.9 сая төгрөгийн, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 4,490.4 сая төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулсан байна.

3.5.7 Судалгааны үр дүн:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас авсан судалгааны үр дүнг нэгтгэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын орон тоог нийт 1,930 байхаар баталсан ба орон дутуу ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэлээр 1,803 орон тоотой ажилласан байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг тус тус үндэслэн алба хаагчдын хоолны мөнгөнд 4,000.00-35,000.00 төгрөг, унааны мөнгөнд 0-8,000.00 төгрөг зэрэг харилцан адилгүй байдлаар олгож байна.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд 863.7 сая төгрөгийн 544 хурал цуглаан зохион байгуулах арга хэмжээ төлөвлөснөөс 768.9 сая төгрөгийн 336 хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 41 хуулийн этгээдтэй нийт 1,650.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 1,627.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж байгаа 3,251.1 сая төгрөгийн 99 төрлийн программ хангамжид тайлант онд 15.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд 8 байгууллагад 239.6 сая төгрөгийн өртэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах төсвийг зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөх, төсвийг бодитой төлөвлөх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөх, хэрэгжилтийг хуулийн хугацаанд ханган ажиллах, хөтөлбөр, арга хэмжээний зардалд үндсэн үйл ажиллагаанд хамаарах урсгал зардал болон хөрөнгийн шинжтэй зардлыг төлөвлөхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор Ч.Мөнхбулган, С.Алтанхуяг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ТНБД-ын 02/1070 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 647,626.1 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 6,476.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан авахгүй байх, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр зардлыг хэмнэх зэрэг бодлого баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 43,315.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 36,412.2 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 6,902.7 сая төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. /ТЕЗ дүн ороогүй/

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ХХААХҮС болон түүний эрхлэх асуудлын хүрээний 1 төвлөрүүлэн захирагч, төсвийн 55 байгууллага, 1 ЗГТС, төрийн өмчит 5 хуулийн этгээд, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй 4 төслийн байгууллага, нийт 65 байгууллага 3266 мэдээлэл байршуулахаас 3169 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 89 мэдээллийн хугацааг хоцроож, 7 мэдээллийг байршуулаагүй, нийт мэдээллийн 97.0 хувийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

а/ Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн байна.

4.4.2.1 Албан шаардлага

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор “Мал эмнэлэгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ-ыг “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” УТҮГазарт нэгтгэн “Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарч, нэгтгэх, шилжүүлэх ажлыг ХХААХҮС-д даалгасан ажил удаашралтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5-т өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”; Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн байгуулах тухай” 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолоор үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.4.2.2 Зөвлөмж

Илрүүлэлт:

1. МУЗГ-ын 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн “Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай” 250 дугаар тогтоол гарч 23.000.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг сурагчийн дүрэмт хувцасны үйлдвэрлэл эрхлэгчдэд 2013 онд багтаан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хөнгөлөлттэй зээлээр олгохыг Хөдөлмөрийн сайдад зөвшөөрсүгэй гэсэн шийдвэр гарсан. Тогтоолын хүрээнд Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-г байгуулсан бөгөөд уг гэрээнд заасан

хамтарсан хяналтын зөвлөл хяналтаа хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЯ-9/2013/02, ҮХААЯ-20131716 тоот гэрээний 2 дугаар зүйлийн 2.7-д "Зээлийн баталгаа: Зээл, зээлийн хүүг эргэн төвлөрүүлэх, зээлийн эрсдэлийг ҮХААЯ бүрэн хариуцна.", 2.8-д "Зээл олгох ААН-ийг шалгаруулах, зээлийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн яам, БШУЯ, ҮХААЯ-ны хамтарсан хяналтын зөвлөл ажиллана. Хамтарсан хяналтын зөвлөлийг ҮХААЯ-ны ТНБД даргалж, БШУЯ-ны төлөөлөл нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ", 4 дүгээр зүйлийн 4.4-т "Төслийн хэрэгжилтийн явцад гарч буй аливаа алдаа зөрчлийг тухай бүрт Сангийн яам, БШУЯ, ҮХААЯ-ны хамтарсан хяналтын зөвлөлд бичгээр мэдэгдэн шийдвэрлүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сурагчийн дүрэмт хувцас эрхлэгчдэд олгосон дамжуулан зээлийн эргэн төлөлтийг Хөдөлмөр эрхэлтийг дэмжих санруу тооцоо нийлсэн актгүйгээр шууд төвлөрүүлж байгаа асуудлыг хянан удирдаж, удаашралтай байгаа асуудлын талаар арга хэмжээ авах.

б/ Түүврийн байгууллага / ХХААХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, Техник хяналтын зардал, Хөтөлбөр, арга хэмжээний зардал /

Илрүүлэлт:

1. Хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд нэвтрүүлэг бэлтгэх, сурталчилан таниулах ажлын 80.0 сая төгрөгийн төсөвт өртгийг шууд гэрээ байгуулах үнийн дүнд багтаан жижиглэж, гэрээ шууд байгуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээг багцалж, хуульд нийцүүлж тендэр зарлаж ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудтай хэсэгчлэн нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 80,687.8 сая төгрөгийн хүргүүлсэн 2 албан шаардлага, өгсөн 6 зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтад үндэслэн хянахад хэрэгжилт 57.6 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	80,687.8	1	2,608.6	3.3
Зөвлөмж	6	-	5	-	83.0
Нийт дүн	8	6,646.1	4	2,035.1	43.2

Өмнөх аудитаар өгсөн 2013 оноос үүсэлтэй дамжуулан зээлийн төлбөрийн үлдэгдлийн талаарх, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж төслийн хүрээнд Чингис хаан банканд байршиж буй 6,088.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлээгүй зэрэг зөрчлүүдэд өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа тул зөрчлийг арилгуулах талаар дахин албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагууд нь 2024 оноос Дархан-Уул аймагт шилжин байршин үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Тус яамнаас хэрэгжүүлж байгаа “Хүнсний хувьсгал”, “Атрын IV”, “Цагаан алт” зэрэг хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтүүд яамны хөтөлбөр арга хэмжээ гэсэн дансаар дамжиж, аудитын түүвэрт хамрагдаж байгаа нь аудитын цаглаварт хугацаанд үр дүнтэй шийдвэр гаргахад хязгаарлагдмал байна. Иймд дээрх хөтөлбөрүүдийн үр ашигт сэдэвчилсэн аудит оруулах нь зүйтэй байна;
- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж” төслийн Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж байгаа 6,088.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх ажил удаашралтай байгаа талаарх зөрчлийг дахин нягтлах;
- Засгийн газрын “Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай” 2013 оны 250 дугаар тогтоолын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан руу шилжүүлж буй мөнгөн хөрөнгийн талаарх асуудлыг дахиx хянах;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,336.0 сая төгрөгийн 81 алдаа илэрснээс аудитын явцад 14,336.0 сая төгрөгийн 81 алдааг залруулж ажилласан байна.

Аудитаар нийт санхүүгийн 215,455.9 сая төгрөгийн 200 зөрчил¹ илэрснээс, 72.1 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 109,433.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 87 албан шаардлага хүргүүлж, 18,929.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 80 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 6,476.2 сая төгрөгөөс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

5.1 Харьяа байгууллагууд

ТЕЗ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 65 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 53 байгууллагад дүгнэлт гаргаж /Өөрчлөлтгүй 35, Хязгаарлалттай 18, / 12 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж аудитыг гүйцэтгэсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 14,336.0 сая төгрөгийн 81 алдаа илэрснээс аудитын явцад 14,336.0 сая төгрөгийн 81 алдааг залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 212,403.0 сая төгрөгийн 194 зөрчил илрүүлсэнд 72.1 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 108,973.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 84 албан шаардлага хүргүүлж, 16,336.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 77 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүү, нийцлийн 3,052.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

1. ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн 212,403.1 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 43,315.0 сая төгрөг, нийт 255,718.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК санхүүгийн тайланд Хөдөө аж ахуйн бага оврын трактор, жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд жимсгэний суулгацыг дамжуулан олгосон зээлийн болон бусад үндсэн дэмжлэгтэй холбоотой үүссэн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамаарах авлага бүртгэлтэй боловч үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй болон “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж” төслийн Чингис хаан банканд байршиж буй 6,088.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх ажлыг эрчимчүүлэх талаар өмнөх аудитаар өгсөн 2 шийдвэрийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, ...” 20.2.6-д “Эд хөрөнгийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа, хэтэрсэн, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах талаарх өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн биелэлтэд хэрэгжүүлсэн хяналт хангалтгүй, шат дараатай арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

3. ХХААХҮЯ-ны харьяа байгууллагууд Дархан-Уул аймагт шилжин суурьших ажлын хүрээнд орон сууцны урьдчилгаа төлбөр олгосон 4 албан хаагч өөр байгууллагад шилжин томилогдсонтой холбогдуулан 243.9 сая төгрөгийн, зээлийн шаардлага хангаагүйн улмаас 4 хүний 215.9 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Орон сууцны урьдчилгаа олгох гэрээ”-ний 2.1.3-д “Албан хаагч энэхүү гэрээг зөрчсөн тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 30 хувийг буцаан нэхэмжилж, урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байгууллагын дансанд буцаан тушаалгах” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн биелэлтийг хангуулан, авлага барагдуулж ажиллах талаарх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

а/ ХХААХҮС-ын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 тушаалаар батлагдсан Төсвийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг удаа дараа хийж, батлагдсан хөтөлбөр арга хэмжээний мөнгөн дүнд материаллаг хэмжээний өөрчлөлтийг оруулж, төсвийн тогтвортой байдлыг мөрдөж ажиллаагүй байна.

б/ Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалаар батлаагүй, харьяа байгууллагуудад хуваарилахдаа Төсвийн шууд захирагч бүрээр баталгаажуулж /батлав иж бүрдэл хангаагүй/ төсвийн захирагч нарт хүргүүлээгүй, тус яамны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10/4018 дугаар бүхий албан бичгийн дагуу батлагдсан төсвийг хүргүүлсэн гэх боловч хавсралт байхгүй. /Батлагдсан төсвийг хавсралтаар хүргүүлж байна гэсэн боловч хавсралт файлыг албажуулаагүй, задгай эксэл хүргүүлсэн/.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах", Архивын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "Бүрдүүлэлт тогтмол, бүрэн байх", 23 дугаар зүйлийн 23.1-д "Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална", 23.2.1."Албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах"; 23.2.6-д "архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх", Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаал "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2.1.2."Төсвийн захирагч болон түүний харьяа төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад хууль, тогтоомжийн дагуу өөрчлөлт орсон, шинээр үүссэн, өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн төлөвлөгөөг хуулийн дагуу эдийн засгийн ангилалаар баталж төсвийн захирагч нарт хүргүүлж хэвших, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөг төсвийн саналд суурилж бодитой төлөвлөж, төсвийн тогтвортой байдлыг мөрдөж ажиллах.

Илрүүлэлт 2:

2. Тайлант хугацаанд ЖДҮХС нь 11 аймагтай гэрээ байгуулан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжилтэд 6,635.8 сая төгрөгийг төвлөрүүлснээр тус байгууллагын төсвийн гүйцэтгэл 2,365.3 сая төгрөгөөр хэтэрсэн нь төсөв батлах цаглаварт хугацаанаас хамаарч уг төсвийг төлөвлөх, батлах боломжгүй нөхцөл байдал үүссэн, төсвийн тодотоголоор төсвийг нэмж батлуулаагүй зэрэг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх", 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.6.6-д "Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 21 дүгээр зүйл 21.3 "Аймаг,

нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөв байна", 22 дугаар зүйлийн 22.6.4-т "Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах"; 42 дугаар зүйлийн 42.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ", Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаал "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2.1.2."Төсвийн захирагч болон түүний харьяа төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад хууль, тогтоомжийн дагуу өөрчлөлт орсон, шинээр үүссэн, өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт тусгаагүй, орон нутгийн төсвөөс орж буй санхүүжилтийг хуульд нийцүүлэн батлууж, зарцуулж байх.

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 3:

3. Малын удмын сангийн үндэсний төвийн тайланд МУ-ын таван хошуу малын генетикийг судлах, судалгааны чиглэлээр НҮБ-аас хэрэгжүүлж байгаа төсөл, БНСУ-ын "Копиа-Монгол" төвтэй хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол оронд тохиромжтой үхрийн аж ахуйн технологи нутагшуулах" төслийн санхүүжилтүүдийн он дамжин зарцуулагдах 227.7 сая төгрөгийг тооцоо нийлж акт үйлдээгүй, хоорондын тооцоо хийж баталгаажуулаагүйн улмаас улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.11."өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд тухай бүр хяналт тавьж ажиллах.

5.3 Түүврийн байгууллага / ХХААХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, Техник хяналтын зардал, Хөтөлбөр, арга хэмжээний зардал /

5.3.1 Төлбөрийн акт

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний 6.2 сая төгрөгийн чанарын баталгааны зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д " Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д " төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн

хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл”, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна", 14.4-т "Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.9-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний чанарын баталгааны зарцуулагдаагүй үлдэгдэл 6.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хянаж үзэхэд дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажилаагүй байна. Үүнд: Хөтөлбөр арга хэмжээний зардалд ХХААХҮЯ-ны аппаратын үндсэн үйл ажиллагаанд хамаарахуйц урсгал зардлыг төлөвлөж, санхүүжүүлж байна. /Тухайлбал; 1. ХАА салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал, салбар дундын арга хэмжээ зэрэг хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилалд үндсэн үйл ажиллагаанд хамаарахуйц салбарын бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах хэвлэл мэдээллийн зардалд 1,419.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. 2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.10.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах ажилд 10,700.0 сая төгрөгийг урсгал зардлын ангилалд төлөвлөн, хэрэгжүүлсэн байна зэрэг зөвлөмжийг/ тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.3.3 Зөвлөмж

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт1:

ХХААХҮС-ын /Баянхонгор/ ЭШХО-Барилга байгууламж 1,799.9 сая төгрөг, ХХААХҮС-ын /Сэлэнгэ/ ЭШХО-Барилга байгууламж-1,996.5 сая төгрөгийн гүйцэтгэл, мэдээ тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем/publicinvestment.gov.mn/-д оруулж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлнэ"; Засгийн газрын 2023 оны 278-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 1.6. Энэ журмын 1.5-д зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах,

мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр хэрэгжүүлнэ; Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын 3.4-т “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалын 6.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан боловч худалдан авах ажиллагаа нь орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг тухайн орон нутгийн захиргааны байгууллага сар бүр энэ журмын зургаадугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, дараа сарын 3-ны дотор тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан эрх шилжсэн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг цахим системээр тайлагнаж хэвших.

Илрүүлэлт2:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлж дууссан ажлуудыг ашиглагч талд шилжүүлэх талаар ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулаагүй 9,528.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ бусад эргэлтийн хөрөнгө дансанд байршиж байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" , ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын, 5.4.6-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлж, хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллах, ТӨБЗГ-т хүсэлт хүргүүлж, ашиглагч байгууллагад шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
I. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага													
1	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	8	6,300.9			8	6,300.9	8	6,300.9				
2	Зээлийн батлан даалтын сан	3	4,531.3			3	4,531.3	3	4,531.3				
	Дүн	11	10,832.2			11	10,832.2	11	10,832.2				
II. Төсвийн шууд захирагч													
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	1.4			1	1.4	1	1.4				
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалт	1	42.0			1	42.0	1	42.0				
5	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	2	10.5			2	10.5	2	10.5				
6	Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	31.9			2	31.9	2	31.9				
7	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	3.9	1	2.1	1	1.8	2	3.9				
8	Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	7.2			1	7.2	1	7.2				
9	Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	3	23.2			3	23.2	3	23.2				
10	Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	93.3			1	93.3	1	93.3				
11	Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	0.5			1	0.5	1	0.5				
12	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	6.0			2	6.0	2	6.0				
13	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	723.2			2	723.2	2	723.2				
14	Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	3.0			1	3.0	1	3.0				
15	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	8.4			1	8.4	1	8.4				
16	Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	75.8			1	75.8	1	75.8				
17	Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	4	49.5	2	7.8	2	41.7	4	49.5				
18	Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	19.0			1	19.0	1	19.0				
19	Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	2.0			1	2.0	1	2.0				
20	Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	38.2			1	38.2	1	38.2				
21	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар	1	489.6			1	489.6	1	489.6				
22	Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газар	3	567.6			3	567.6	3	567.6				
23	Булган аймгийн Мал эмнэлгийн газар	2	78.0			2	78.0	2	78.0				
24	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	1	352.3			1	352.3	1	352.3				
25	Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	1	14.4			1	14.4	1	14.4				

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

26	Дархан аймгийн Мал эмнэлгийн газар	1	14.5			1	14.5	1	14.5				
27	Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар	5	104.4	3	73.1	2	31.3	5	104.4				
28	Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар	6	55.9	1	4.4	5	51.5	6	55.9				
29	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	2	18.0	1	13.6	1	4.4	2	18.0				
30	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	1	11.7			1	11.7	1	11.7				
31	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	2	11.5			2	11.5	2	11.5				
32	Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар	1	1.7			1	1.7	1	1.7				
33	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	3	299.4			3	299.4	3	299.4				
34	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	2	5.3			2	5.3	2	5.3				
35	Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс	1	5.0			1	5.0	1	5.0				
36	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	5	230.0			5	230.0	5	230.0				
37	Малын удмын сангийн үндэсний төв	5	105.3	3	79.9	2	25.4	5	105.3				
	Дүн	70	3,503.6	11	180.9	59	3,322.7	70	3,503.6				
	НИЙТ ДҮН	81	14,335.8	11	180.9	70	14,154.9	81	14,335.8				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
I. Төсвийн ерөнхийлөн захирагч												
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	6	3,052.9			3	459.8	3	2,593.1			
	Дүн	6	3,052.9			3	459.8	3	2,593.1			
II. Засгийн газрын тусгай сан												
2	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	7	36,716.5			5	36,653.7	2	62.8			
	Дүн	7	36,716.5			5	36,653.7	2	62.8			
III. Төсвийн төвлөрүүлэн захирагч												
3	Мал эмнэлгийн Ерөнхий газар ТТЗ	6	13,913.6			2	13,913.6	4	-			
	Дүн	6	13,913.6			2	13,913.6	4	-			
IV. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага												
4	Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК	4	211.1			4	211.1					
5	Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК	3	289.2			3	289.2					
6	Биокомбинат ТӨХХК	6	598.6			5	510.8	1	87.8			
7	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	13	141,651.3			7	54,363.1	5	300.9	1		86,987.3
8	Зээлийн батлан даалтын сан	5	210.6	1	1.6	3	189.7	1	19.3			
	Дүн	31	142,960.8	1	1.6	22	55,563.9	7	408.0	1		86,987.3
V. Төсвийн шууд захирагч												
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	11	437.5			5	157.3	6	280.2			
10	ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалт	3	13,330.9	1	6.2			2	13,324.7			
11	ХХААХҮЯ-ны хөтөлбөр, арга хэмжээ	1	-			1	-					
12	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	16	1,798.1	1	3.2	11	1,775.6	4	19.3			
13	Жижиг дунд үйлдвэрийн газар	5	210.6	1	1.6	3	189.7	1	19.3			
14	Архангай аймгийн ХХААГ	2	40.3			2	40.3					
15	Баянхонгор аймгийн ХХААГ	1	-					1	-			
16	Булган аймгийн ХХААГ	2	0.7	1	0.3			1	0.4			
17	Говь-Алтай аймгийн ХХААГ	4	25.2			3	22.5	1	2.7			
18	Дорнод аймгийн ХХААГ	3	20.9	1	1.6	1	-	1	19.3			
19	Дундговь аймгийн ХХААГ	1	0.5			1	0.5					

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Завхан аймгийн ХХААГ	1	1.6			1	1.6					
21	Орхон аймгийн ХХААГ	3	18.0					3	18.0			
22	Сэлэнгэ аймгийн ХХААГ	4	168.0	1	0.8			3	167.2			
23	Төв аймгийн ХХААГ	5	127.4	1	1.8	2	101.1	2	24.5			
24	Увс аймгийн ХХААГ	1	1.9					1	1.9			
25	Ховд аймгийн ХХААГ	4	262.6			1	249.6	3	13.0			
26	Хөвсгөл аймгийн ХХААГ	1	7.2					1	7.2			
27	Хэнтий аймгийн ХХААГ	1	20.1			1	20.1					
28	Нийслэлийн МЭГ	5	7.0					5	7.0			
29	Архангай аймгийн МЭГ	1	19.5			1	19.5					
30	Баян-Өлгий аймгийн МЭГ	3	527.8	1	1.6			2	526.2			
31	Булган аймгийн МЭГ	10	90.0	6	24.2	2	13.1	2	52.7			
32	Баянхонгор аймгийн МЭГ	2	0.6	1	0.6	1	-					
33	Говь-Сүмбэр аймгийн МЭГ	4	49.3	1	0.2	2	43.5	1	5.6			
34	Дархан аймгийн МЭГ	1	0.8			1	0.8					
35	Дорнод аймгийн МЭГ	1	0.1	1	0.1							
36	Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар	5	22.1	2	9.7	1	4.2	2	8.2			
37	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	3	3.2	2	1.1	1	2.1					
38	Завхан аймгийн МЭГ	2	11.2	1	2.9			1	8.3			
39	Орхон аймгийн МЭГ	3	9.0	1	5.2	1	3.8	1	-			
40	Өмнөговь аймгийн МЭГ	1	4.6			1	4.6					
41	Сүхбаатар аймгийн МЭГ	3	91.3					3	91.3			
42	Төв аймгийн МЭГ	4	48.2			3	28.2	1	20.0			
43	Ховд аймгийн МЭГ	4	11.3	1	1.6	1	7.4	2	2.3			
44	Хөвсгөл аймгийн МЭГ	1	1.5					1	1.5			
45	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	4	28.9	1	0.6	1	28.3	2	-			
46	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	3	7.5	2	3.5			1	4.0			
47	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа	1	31.3					1	31.3			
48	Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс	5	134.1	1	1.2	2	35.3	2	97.6			
49	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	6	127.0			5	93.4			1		33.6
50	Малын удмын сангийн үндэсний төв	8	1,114.0	2	2.5			6	1,111.5			
51	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл	1	0.3					1	0.3			
	Дүн	150	18,812.1	30	70.6	55	2,842.5	64	15,865.4	1		33.6

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	НИЙТ ДҮН	200	215,455.9	31	72.2	87	109,433.5	80	18,929.3	2	87,020.9
--	-----------------	------------	------------------	-----------	-------------	-----------	------------------	-----------	-----------------	----------	-----------------

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил			Үүнээс						Албан шаардлага / хариуцлага тооцуулах /		
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Хүний тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хүний тоо
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
I. Төсвийн ерөнхийлөн захирагч													
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	2	-				1	-	1	-			
	Дүн	2	-				1	-	1	-			
II. Засгийн газрын тусгай сан													
2	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	1	27,605.2				1	27,605.2					
	Дүн	1	27,605.2				1	27,605.2					
III. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага													
3	Биокомбинат ТӨХХК	3	123.4				2	123.4	1	-			
4	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	2	412.1						2	412.1			
5	Зээлийн батлан даалтын сан	1	301.4				1	301.4					
	Дүн	6	836.9				3	424.8	3	412.1			
IV. Төсвийн шууд захирагч													
6	ХХААХҮЯ-ны хөтөлбөр, арга хэмжээ	1	80.0						1	80.0			
7	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	3	2,021.4				1	2,021.4	2	-			
8	Жижиг дунд үйлдвэрийн газар	1	301.4				1	301.4					
9	Архангай аймгийн ХХААГ	1	-								1	-	
10	Булган аймгийн ХХААГ	1	-						1	-			
11	Өвөрхангай аймгийн ХХААГ	1	-						1	-			
12	Төв аймгийн ХХААГ	1	-						1	-			
13	Хөвсгөл аймгийн ХХААГ	1	-						1	-			
14	Хэнтий аймгийн ХХААГ	2	54.6				2	54.6					
15	Нийслэлийн МЭГ	2	2,593.5				1	39.0	1	2,554.5			
16	Баян-Өлгий аймгийн МЭГ	1	777.0						1	777.0			
17	Булган аймгийн МЭГ	3	9.3						3	9.3			
18	Говь-Сүмбэр аймгийн МЭГ	2	1.7						2	1.7			
19	Дорнод аймгийн МЭГ	1	749.7				1	749.7					
20	Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар	1	-						1	-			
21	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	1	123.4						1	123.4			
22	Орхон аймгийн МЭГ	1	-						1	-			
23	Өвөрхангай аймгийн МЭГ	1	-						1	-			

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

24	Өмнөговь аймгийн МЭГ	1	-					1	-			
25	Увс аймгийн МЭГ	1	2,769.2					1	2,769.2			
26	Хөвсгөл аймгийн МЭГ	1	-					1	-			
27	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	1	-			1	-					
28	Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс	1	1,458.1			1	1,458.1					
29	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	2	175.5					2	175.5			
30	Малын удмын сангийн үндэсний төв	1	3,758.1			1	3,758.1					
	Дүн	32	14,872.9			9	8,382.3	22	6,490.6	1	-	
	НИЙТ ДҮН	39	43,315.0			14	36,412.3	26	6,902.7	1	-	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1446/АД11371

Улаанбаатар хот

САГ-2026/26/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллагууд Дархан-Уул аймагт шилжин суурьших ажлын хүрээнд орон сууцны урьдчилгаа төлбөр олгосон 4 албан хаагч өөр байгууллагад шилжин томилогдсонтой холбоотой 243,939,000.00 /Хоёр зуун дөчин гурван сая есөн зуун гучин есөн мянга/ төгрөгийн, зээлийн шаардлага хангаагүйн улмаас 4 хүний 215,887,500.00 /Хоёр зуун арван таван сая найман зуун наян долоон мянга таван зуу/ төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Орон сууцны урьдчилгаа олгох гэрээ"-ний 2.1.3-т "Албан хаагч энэхүү гэрээг зөрчсөн тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 30 хувийг буцаан нэхэмжилж, урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байгууллагын дансанд буцаан тушаалгах" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулан, авлага барагдуулж ажиллах талаарх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Ц.Идэрбат), Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга(Г.Болорсүх) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAC\55 Docx

1526182396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1445/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/26/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ-ыг “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” УТҮГ-т нэгтгэн “Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр, гарч, нэгтгэх, шилжүүлэх ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан боловч 2 байгууллагыг нэгтгэн өөрчлөн зохион байгуулаагүй, бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг баталж мөрдүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.”, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн байгуулах тухай” 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоолоор үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Ц.Идэрбат), Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга(Г.Болорсүх) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga-2026\0424 SAG-55.Docx

1526182398



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1444/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/26/КА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК санхүүгийн тайланд Хөдөө аж ахуйн бага оврын трактор, жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд жимсгэний суулгацыг дамжуулан олгосон зээлийн болон бусад үндсэн дэмжлэгтэй холбоотой үүссэн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамаарах авлага бүртгэлтэй боловч үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй болон “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж” төслийн Чингис хаан банканд байршиж буй 6,088.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар өмнөх аудитаар өгсөн 2 шийдвэрийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, ...” 20.2.6-д “Эд хөрөнгийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах талаарх өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн биелэлтэд хэрэгжүүлсэн хяналт хангалтгүй, шат дараатай арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Ц.Идэрбат), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга (Г.Болорсүх) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

Ө.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga-2026\0424 SAG-55.Docx

1526182400



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1447/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/26/КА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн 212,403,071,800.00/Хоёр зуун арван хоёр тэрбум дөрвөн зуун гурван сая далан нэгэн мянга найман зуу/ төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 43,314,970,900.00/Дөчин гурван тэрбум гурван зуун арван дөрвөн сая есөн зуун далан мянга есөн зуу/ төгрөг, нийт 255,718,042,700.00 /Хоёр зуун тавин таван тэрбум долоон зуун арван найман сая дөчин хоёр мянга долоон зуу/ төгрөгийн зөрчил илэрсэн байна.


Энэ нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Ц.Идэрбат), Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга(Г.Болорсүх) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН



С.МАГНАЙСҮРЭН